

“МОНОС ХҮНС” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 05 сарын 10-ны өдөр

№ 05/05

Улаанбаатар хот

“Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-д нэмэлт өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13 дахь заалт, 80 дугаар зүйлийн 80.4 дэх заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20-р зүйлийн 20.1.10 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 145 тоот тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодексы”, “Монос Хүнс” ХК-ийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.6 дугаар заалт зэргийг тус тус үндэслэн 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас ТОГТООХ нь:

1. Монос хүнс ХК-ийн “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг Хавсралт №01-ээр баталсугай.
2. “Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам”-ыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхээ хэрэгжүүлэх явцад дагаж мөрдөн ажиллахыг ТУЗ-ийн гишүүдэд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА

ТУЗ-ИЙН ГИШҮҮД

 Х.АНАНД

 Л.ХҮРЭЛБААТАР

 Ч.БАТТОГТОХ

 Б.ГАНТУЛГА

 О.ЛХАГВАСҮРЭН

 Х.СОЛОНГО

 Ц.ЦЭЦЭГБАДАМ

 А.ОТГОНДАРЬ





Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын
2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн
25.1.25 тоот тогтоолын 1 дүгээр хавсралт

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

[КОМПАНИЙН ХЭРЭГЦЭЭНД]

Баримт бичгийн төрөл:	Журам
Хамрах хүрээ:	ГУЗ-ийн гишүүд
Хувийг хадгалах:	ГУЗ-ийн нарийн бичгийн дарга
Баталсан:	Х.Ананд /ГУЗ-ийн дарга/
Хуудасны тоо: хуудас
Батлагдсан огноо:	2019 оны 08 дугаар сарын 26
Шинэчилж сайжруулсан огноо:	2021 оны 05 дугаар сарын 17 2023 оны 05 дугаар сарын 10

10/3
10
10/3

АГУУЛГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

ХОЁР. ТУЗ-ИЙН БҮРЭН ЭРХ, ЧИГ ҮҮРЭГ

ГУРАВ. ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН

ДӨРӨВ. ТУЗ-ИЙН ДАРГА

ТАВ. ТУЗ-ИЙН ГИШҮҮД

ЗУРГАА. ТУЗ-ИЙН БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦАА

ДОЛОО. НЭР ДЭВШҮҮЛЭХ

НАЙМ. ГИШҮҮНЭЭР СОНГОХ БА ЧӨЛӨӨЛӨХ

ЕС. ЦАЛИН ХӨЛС, УРАМШУУЛАЛ

АРАВ. ТУЗ-ИЙН ХУРАЛ

АРВАН НЭГ. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

АРВАН ХОЁР. ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ

АРВАН ГУРАВ. ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН МӨРДӨХ ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

АРВАН ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1. Энэхүү журмаар “Монос Хүнс” ХК-ийн (цаашид “компани” гэх) Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн бүрэн эрх, түүний гишүүдийн эрх, чиг үүрэг, хариуцлага, бүрэн эрхийн хугацаа, нэр дэвшүүлэх, сонгох, чөлөөлөх журам, гишүүдийн цалин урамшуулал, гишүүдийн үйл ажиллагааг тодорхойлох, ТУЗ-ийн хурал хуралдуулах, ТУЗ-ийн үйл ажиллагааг дүгнэх, тайлагнах зэрэг харилцааг зохицуулна.
- 1.2. ТУЗ-ийн үндсэн зорилго нь компанийн үйл ажиллагааг удирдан чиглүүлэх, удирдлага зохион байгуулалт, санхүү эдийн засгийг бэхжүүлэх, компанийн цаашдын бодлого чиглэлийг тогтоох, тэдгээрийн хэрэгжилтэнд хяналт тавих, гүйцэтгэх захирлын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч дэмжлэг туслалцаа үзүүлэхэд оршино.
- 1.3. Компани болон гишүүн хоорондын харилцааг Иргэний хуульд заасан гэрээгээр зохицуулах ба тус гэрээнд компанийн нэрийн өмнөөс ТУЗ-ийн дарга гарын үсэг зурна.
- 1.4. Энэхүү журмыг Компанийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 145 тоот тогтоолоор батлагдсан “Компанийн засаглалын кодексе”, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актад нийцүүлэн боловсруулав.
- 1.5. Журмыг ТУЗ-ийн хурлаар баталсан өдрөөс эхлэн үйл ажиллагаандаа мөрдөх бөгөөд журамд нэмэлт өөрчлөлт оруулах эрхийг ТУЗ эдэлнэ.

ХОЁР.ТУЗ-ИЙН БҮРЭН ЭРХ, ЧИГ ҮҮРЭГ

- 2.1. ТУЗ нь хууль болон компанийн дүрмийн дагуу ХЭХ-ын бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэх асуудлаас бусад компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлагнал, мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах, хяналтын болон эрсдэлийн удирдлагын тогтолцоонд хяналт тавих, сайн засаглалыг хэрэгжүүлэх, хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хангах, гүйцэтгэх удирдлагад хяналт тавих зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.
- 2.2. ТУЗ-ийн бүрэн эрх дараах үйл ажиллагааг хамаарна. Үүнд:
 - 2.2.1. Гүйцэтгэх удирдлагын зөвлөмж, бэлтгэл ажлын дагуу компанийн жилийн санхүү, бизнес төлөвлөгөө гэх мэт компанийн стратеги, бизнесийн тэргүүлэх чиглэл болон компанийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох;
 - 2.2.2. Компанийн урт, богино хугацааны санхүүгийн болон үйл ажиллагааны хөрөнгө оруулалтын нэгдсэн төлөвлөгөөг батлах, тэдгээрийн гүйцэтгэлийн талаар дүгнэлт гаргах;
 - 2.2.3. Гүйцэтгэх захирлыг томилох, чөлөөлөх; гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлэх тохиолдолд гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдийг томилох, чөлөөлөх тэдгээрийн бүрэн эрхийг тодорхойлох;
 - 2.2.4. Салбар, төлөөлөгчийн газар хэлтэс, алба байгуулах, татан буулгах, тэдгээрийн дотоод журмыг батлах;
 - 2.2.5. Компанид хадгалж байвал зохих нэмэлт баримт бичгийн жагсаалт гаргах;
- 2.3. ХЭХ-д бэлтгэх, хурлыг зохион байгуулахтай холбоотой ТУЗ-ийн бүрэн эрх дараах үйл ажиллагааг хамаарна. Үүнд:
 - 2.3.1. Хэрэв саналын хуудсаар урьдчилан санал авах тохиолдолд ХЭХ болох огноо, газар, эхлэх цаг, бөглөсөн саналын хуудсаа илгээх шуудангийн хаягийг тодорхойлох, саналын хуудсыг хүлээн авах сүүлчийн өдрийг тодорхойлох;
 - 2.3.2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (ХЭЭХ) болон хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлах (ХЭЭБХ);

- 2.3.3. ХЭХ-аар хэлэлцэх асуудал, саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалтыг гаргах бүртгэлийн өдөр болон хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахтай холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх, саналын хуудасны маягт, агуулгыг батлах;
- 2.3.4. Хувьцаа эзэмшигчийн хурлаар ажиллах тооллогын комиссын гишүүдийг томилох.
- 2.3.5. Дараах тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлана. Үүнд:
 - 2.3.5.1. ТУЗ-ийн гишүүдийн 50%-иас дээш тооны гишүүд ажиллах боломжгүй болсон;
 - 2.3.5.2. Хэрэв хоёр (2) эсвэл түүнээс дээш тооны хараат бус гишүүд, 10 болон түүнээс дээш хувийн саналын эрхтэй хувьцаа эзэмшигч санал гаргасан, шаардлага тавьсан;
 - 2.3.5.3. Жилийн санхүүгийн тайлан гаргах үед компанийн алдагдал компанийн нийт өөрийн хөрөнгийн 30%-иас давсан;
 - 2.3.5.4. Компанийн өрийн хэмжээ хоёр (2) жил дараалан өөрийн хөрөнгөөс илүү болж, хасах утгатай болсон;
 - 2.3.5.5. ТУЗ шийдвэр гаргасан;
 - 2.3.5.6. Аудитын хорооноос хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хийх хүсэлт тавьсан;
- 2.3.6. ХЭХ-ын ээлжит бус хурлын саналыг авч үзэх, хурал зарлах хүсэлт хүлээн авсны дараа ажлын арван (10) хоногийн дотор ХЭХ зарлах эсвэл зарлах үйл ажиллагаанаас татгалзах шийдвэр гаргах; шийдвэрийг сонирхсон талуудад нэн даруй мэдэгдэх;
- 2.3.7. Хурал хийх тухай мэдэгдэл гаргасан өдрөөс эхлэн хувьцаа эзэмшигчдэд хэлэлцэх асуудалтай холбогдох баримт бичигтэй танилцах боломжоор хангана.
- 2.3.8. Дараах асуудлуудыг ХЭХ-д оруулж, хэлэлцүүлнэ. Үүнд:
 - 2.3.8.1. Компанийг өөрчлөн байгуулах, өөрчлөн байгуулалтын хэлбэр болон холбогдох асуудлууд;
 - 2.3.8.2. Компанийг татан буулгах, татан буулгах комисс байгуулах, холбогдох бичиг баримтыг батлах;
 - 2.3.8.3. Жилийн тайлан батлах;
 - 2.3.8.4. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх;
 - 2.3.8.5. Хувьцааг хуваах, нэгтгэх;
 - 2.3.8.6. Нийт гишүүд нь тухайн хэлцэлд ашиг сонирхлын зөрчилтэй байх, эсвэл тухайн хэлцэлд сонирхлын зөрчилгүй гишүүд дотор нь хараат бус гишүүд байхгүй байгаагаас шалтгаалан сонирхлын зөрчилтэй хэлцлийг байгуулах боломжгүй болсон үед тухайн хэлцлийг батлах эсэхийг шийдүүлэхээр;
 - 2.3.8.7. Компани өөрийн хувьцааг худалдаж авах;
 - 2.3.8.8. Холдинг, санхүү болон үйлдвэрлэлийн групп, худалдааны байгууллагуудын бусад бүлэглэлд оролцох оролцоо;
 - 2.3.8.9. ТУЗ, ХЭХ-ын дотоод дүрэм, журмыг батлах;
 - 2.3.8.10. ТУЗ-ийн гишүүдийн ажлын хөлсийг тогтоох;
- 2.3.9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг дараах хэлбэрээр зохион байгуулж болно. Үүнд:
 - 2.3.9.1. цахим /мэдээллийн технологи, программ хангамж ашиглан хурлын бүх үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах/
 - 2.3.9.2. хосолсон /танхим болон цахим хэлбэрээр/
- 2.4. Компанийн үнэт цаас, үндсэн хөрөнгөтэй холбоотой ТУЗ-ийн бүрэн эрх дараах үйл ажиллагааг хамаарна. Үүнд:
 - 2.4.1. Үндсэн хөрөнгийн үнэлгээг тогтоох, гаргах үнэт цаасны төрөл, тоо, гаргах хугацаа, нөхцөлийг тогтоох;

- 2.4.2. Хэрэв ХЭХ-ын хэлэлцэх асуудалд нэмэлт хувьцаа гаргах, хувьцааны төлбөрийг мөнгөн бус хэлбэрээр хийх зэрэг асуудал тусгагдсан тохиолдолд, хувьцааны төлбөрт төлж болох үндсэн хөрөнгийн жагсаалтыг гаргаж хувьцаа эзэмшигчдэд танилцуулах, энэ төрлийн үндсэн хөрөнгийн үнэлгээний тайлан гаргах;
- 2.4.3. Ногдол ашгийн төлбөрийн хэмжээг тогтоож, ногдол ашиг хуваарилах ажлыг зохион байгуулах;
- 2.4.4. Компанийн нөөц хөрөнгө болон бусад мөнгөн хөрөнгийг ашиглах асуудлыг шийдвэрлэх;
- 2.4.5. Хуульд заасан тохиолдолд их хэмжээний хэлцэл бол бизнес төлөвлөгөөнд тусгагдаагүй тусгай хэлцлийг батлах;
- 2.4.6. Компанийн цэвэр ашгийн 10%-иас дээш үнэтэй хөрөнгөтэй холбогдох гэрээ, хэлцлийг батлах;
- 2.4.7. Нийт гишүүд нь тухайн хэлцэлд ашиг сонирхлын зөрчилтэй байх, эсвэл тухайн хэлцэлд сонирхлын зөрчилгүй гишүүд дотор нь хараат бус гишүүд байхгүй бусад тохиолдолд сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах эсэхийг шийдэх;
- 2.4.8. Санхүү болон бизнесийн төлөвлөгөөнөөс гадна үйл ажиллагааг батлах шийдвэр гаргах ,
- 2.5. Компанийн гүйцэтгэх удирдлагыг чиглүүлэх, хянахтай холбоотой ТУЗ-ийн бүрэн эрх дараах үйл ажиллагааг хамарна. Үүнд:
 - 2.5.1. Байнгын болон түр ТУЗ-ийн дэргэдэх хороодыг байгуулах;
 - 2.5.2. Компанийг төлөөлөн гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, ТУЗ-н нарийн бичгийн даргатай хөдөлмөрийн гэрээ байгуулах, эсвэл бусад албан тушаалтанд компанийг төлөөлөн гэрээ байгуулах эрх олгох;
 - 2.5.3. Компанийн гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд, ТУЗ-ийн нарийн бичгийн ажлын хөлсийг оролцуулан хөдөлмөрийн гэрээний нөхцөлүүдийг тодорхойлох;
 - 2.5.4. Хөндлөнгийн аудитор томилох, түдгэлзүүлэх, түүнтэй байгуулах гэрээний нөхцөлүүдийг тодорхойлох;
 - 2.5.5. Гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдийн өөр компанийн удирдах албанд ажиллах асуудлыг зөвшилцөх;
 - 2.5.7. Компанийн санхүү, бизнесийн үйл ажиллагаанд хөндлөнгийн аудит хийж, тусгай шалгалт явуулах хүсэлт гаргах;
 - 2.5.8. Гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдээс бичгээр үйлдсэн тайлан, чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай бичиг баримт, мэдээлэл авах хүсэлт тавих;
 - 2.5.9. гүйцэтгэх удирдлагын багийн үйл ажиллагаанд хяналт тавих, үнэлэлт, дүгнэлт өгөх, удирдлагын үр ашигтай байдалд мониторинг хийх замаар хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын эрх ашгийг хамгаалах,
 - 2.5.10. Эрсдэлийн удирдлага болон санхүүгийн үйл ажиллагаа, нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байдал, үндсэн үйл ажиллагааны өртөг зардалд мониторинг хийх тогтолцоог бүрдүүлэх,
 - 2.5.11. компанийн үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах талд хяналт тавих,
 - 2.5.12. хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагч, гүйцэтгэх удирдлага, бусад оролцогч талуудын хооронд сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд компанийн эрх ашиг, сайн засаглалын зарчимд нийцүүлэн зөв зохицуулалтыг хийх,
 - 2.5.13. ТУЗ-ийн нарийн бичгийн даргыг томилох, чөлөөлөх;
- 2.6. Гишүүд нь компанийн гүйцэтгэх удирдлага, компанийн бүтэц, нэгжийн дарга нараас өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхэд шаардлагатай мэдээлэл авах эрхтэй.
- 2.7. ТУЗ-ийн эрх хэмжээний хүрээнд шийдвэрлэгдээгүй асуудлуудыг гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багт шилжүүлэхгүй.



ГУРАВ. ТУЗ-ИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- 3.1. ТУЗ-ийн бүрэлдэхүүн, зохион байгуулалт
 - 3.1.1. ТУЗ нь 9 гишүүнээс бүрдэх ба нийт гишүүдийн гуравны нэгээс багагүй тооны гишүүд хараат бус байна. Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хангах, засаглалыг бэхжүүлэх зорилгоор ТУЗ-ийн дарга болон гишүүдийн олонх нь хараат бус гишүүн байхыг зорино.
 - 3.1.2. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч нь хувь хүн байна. Компанийн хувьцаа эзэмшигч биш этгээдийг гишүүнээр сонгож болно.
 - 3.1.3. ТУЗ-ийн үйл ажиллагааны тогтвортой байдлыг хадгалах зорилгоор ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулахдаа нэг удаад 1/3-ээс ихгүй гишүүдийг өөрчлөх тул ТУЗ-ийн гишүүнийг улируулан сонгож болно.
 - 3.1.4. ТУЗ-ийн гишүүн нь аудит, нягтлан бодох бүртгэл, санхүү, хууль эрх зүй, хөрөнгө оруулалтын чиглэлээр мэргэшсэн, дадлага туршлага бүхий ёс зүйн өндөр шаардлага хангасан байвал зохино.
 - 3.1.5. ТУЗ-ийн гишүүн нь өрсөлдөгч компанийн хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, ажилтан байж болохгүй.
 - 3.1.6. Эдийн засгийн гэмт хэрэг үйлдсэн, бизнес, санхүү, татвар, үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагаатай холбоотой зөрчил гаргасан болох нь тогтоогдож шийтгэл хүлээсэн этгээдийг ТУЗ-ийн гишүүнээр сонгохгүй.
 - 3.1.7. ТУЗ-ийн нарийн бичгийн даргын албан тушаалд гишүүнээр ажиллаж байгаа хүнийг томилохгүй.
 - 3.1.8. Компанийн гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдээс ТУЗ-д ажиллах гишүүдийн тоо нь ТУЗ-ийн гишүүдийн дөрөвний нэгээс илүү байж болохгүй.
 - 3.1.9. Гишүүд 3-аас илүү тооны компаниудад нэгэн зэрэг удирдах алба хашихгүй.
 - 3.1.10. ТУЗ-ийн гишүүн нь Компанийн тухай хуулийн 75.8-д заасан шаардлагыг заавал хангасан байна.
 - 3.1.11. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас өмнө ТУЗ-ийн нийт гишүүдийн олонхийн саналаар дуусгавар болгож болно.
 - 3.1.12. ТУЗ нь олон талт ур чадвар, мэдлэг туршлага, хараат бус байдал зэргийг хангасан, үр дүнтэй бүтэцтэй байна.
 - 3.1.13. ТУЗ-ийн гишүүдийн бүрэлдэхүүнд хүйсийн тэнцвэртэй байдлыг хадгалахыг зорих ба аль нэг хүйсийн эзлэх хувийг 30%-с доошгүй байлгана.

ДӨРӨВ. ТУЗ-ИЙН ДАРГА

- 4.1. ТУЗ-ийн даргыг ТУЗ-ийн гишүүдийн дундаас ил санал хураалтаар сонгох ба олонхийн санал авсан дүнгээр ТУЗ-ийн даргыг томилох, чөлөөлөх, дахин сонгох эрхтэй.
- 4.2. ТУЗ-ийн хурлыг ТУЗ-ийн дарга удирдах бөгөөд гишүүдийн санал хурлын үеэр тэнцсэн тохиолдолд тухайн асуудлыг өөрийн саналаар шийдвэрлэх давуу эрх эдэлнэ.
- 4.3. Компанийн гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүнээр ажиллаж байгаа нэр дэвшигчийг ТУЗ-ийн даргаар сонгохгүй.
- 4.4. ТУЗ-ийн дарга дараах үйл ажиллагааг хариуцна:
 - 4.4.1. ТУЗ-ийн ажлыг зохион байгуулах, нийт гишүүдийг санал бодлоо чөлөөтэй солилцох нөхцөлөөр хангах, хэлэлцэх асуудлуудаар нээлттэй хэлэлцүүлэг явуулах;
 - 4.4.2. ТУЗ-ийн уулзалтын хуваарь гаргаж, зохион байгуулах, хурлаар хэлэлцэх асуудлуудыг бэлтгэх, гишүүдийн зөвшөөрлийн бичигт үндэслэн санал хураалт явуулах;

- 4.4.3. Хурлын тэмдэглэл хөтлүүлэх, хянах, тэмдэглэлд гарын үсэг зурах;
 - 4.4.4. Гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүний албан тушаалд нэр дэвшигчтэй холбогдуулан тухайн нэр дэвшигч/нэр дэвшигчид ял шийтгэлтэй эсэх талаар лавлагаа мэдээлэл авах хүсэлт гаргах;
 - 4.4.5. Компанийг төлөөлөн ТУЗ-ийн гишүүн, гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдтэй байгуулах гэрээнд гарын үсэг зурах;
 - 4.4.6. ТУЗ-ийн хурлаар хэлэлцэх асуудлуудын талаарх материалыг бүрдүүлэх, хурлын дэгийн дагуу санал хурааж үр дүнтэй шийдвэр гаргах;
 - 4.4.7. ТУЗ-ийн хороонуудыг байгуулах ажлыг зохион байгуулах, тус хороонуудад гишүүдийг нэр дэвшүүлэх, компанийн ажилтан, гишүүд, хороодын хоорондын харилцааг зохицуулах;
 - 4.4.8. Гүйцэтгэх захирал болон бусад удирдах ажилтнуудтай байнгын харилцаа холбоотой ажиллах;
 - 4.4.9. Компанийн гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүнд нэр дэвшүүлэх;
 - 4.4.10. ХЭХ-ыг өөр албан тушаалтан зарлаж, ХЭХ-ийг даргалах өөр этгээдийг томилсноос бусад тохиолдолд ХЭХ-ыг даргалах;
- 4.5. ТУЗ-ийн даргын эзгүй үед түүний томилсон гишүүн хурлыг удирдана. ТУЗ-ийн дарга аливаа этгээдийг томилоогүй бол хамгийн ахмад гишүүн хурлыг удирдана.

ТАВ. ТУЗ-ИЙН ГИШҮҮД

- 5.1. ТУЗ-ийн гишүүд эрх, үүргээ дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд:
- 5.1.1. Компанийг хөгжүүлэх талаар гарсан бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллана.
 - 5.1.2. Шийдвэр гаргахдаа ул суурьтай, үнэнч шударга хандаж, компани болон хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийн төлөө ажиллана. Өөрөөр хэлбэл бүх боломжит мэдээллийг анхаарч үзэх, ойролцоо нөхцөл байдалд анхааралтай, сайтар бодож боловсруулсан шийдвэр гаргах;
 - 5.1.3. Зарлагдсан хурлуудад оролцох, сонгогдсон ТУЗ-ийн хороодынхоо ажилд оролцох;
 - 5.1.4. Тодорхой бус, ойлгомжгүй асуудлуудын талаар тодруулга хийж, асуулт тавих;
 - 5.1.5. ТУЗ-ийн хуралд оролцох боломжгүй болсон тохиолдолд оролцох боломжгүй шалтгаанаа ТУЗ-д урьдчилан мэдэгдэнэ.
 - 5.1.6. ТУЗ-ийн шийдвэрийг хэрэгжүүлэхэд биечлэн оролцох, түүний биелэлтийн талаар мэдээлэл авах, ТУЗ-ийн эрх хэмжээний асуудлаар хяналт шалгалт явуулна.
 - 5.1.7. ТУЗ-ийн шийдвэрийг хэрэгжүүлэх талаар холбогдох хүмүүст шаардлага тавих, тайлбар гаргуулах, хуралд асуудал оруулж хэлэлцүүлэх, үндэслэл гаргах, шийдвэр батлуулах зэрэг бүрэн эрхтэй.
 - 5.1.8. Компанийн нууц мэдээллийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах дотоод журмаар тогтоосон дүрэм журмын дагуу бүрэн хариуцаж ажиллах, олж мэдсэн нууц, дотоод болон бусад албан мэдээллийг ажиллах хугацаандаа болон компаниас гарснаас хойш хугацаагүйгээр бусдад задруулахгүй байх, хувийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй байх үүрэгтэй.

ЗУРГАА. ТУЗ-ИЙН БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦАА

- 6.1. ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаа 3 жил байх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуульд заасан хугацаанд хуралдуулснаар бүрэн эрх хэрэгжинэ.
- 6.2. Өмнөх ТУЗ-ийн бүрэн эрх дараагийн ТУЗ томилогдоход дуусгавар болно.

- 6.3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Компанийн тухай хуульд заасан хугацаанд хуралдуулаагүй тохиолдолд ТУЗ-ийн ХЭХ-г бэлтгэх, түүнийг зарлах, зохион байгуулахаас бусад Компанийн тухай хууль болон энэ дүрмээр тогтоосон бүрэн эрх дуусгавар болно.
- 6.4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрээр ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох эрхтэй.
- 6.5. Хэрэв гишүүн удаан хугацаагаар үүргээ биелүүлэх боломжгүй болсон, ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан, эсхүл нас барсан бол ТУЗ-өөс орлох хүнийг ХЭХ-ийн ээлжит хурлаар дахин томилогдох хүртэл түр томилж болно.

ДОЛОО. НЭР ДЭВШҮҮЛЭХ

- 7.1. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг тавигдах шалгуур үзүүлэлтийн дагуу сонгон шалгаруулалтаар ТУЗ-ын дэргэдэх Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо анкет бүртгэлийн асуулгыг бүрдүүлэн хийнэ.
- 7.2. ТУЗ нь ТУЗ-ийн гишүүнд тодорхой этгээдийг нэр дэвшүүлэх эрхтэй.
- 7.3. Нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хороо ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэх, тогтоосон шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянах, нэр дэвшигчийн жагсаалтанд бүртгүүлэх ажлыг хариуцан хийх ба ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг ХЭХ-ын хэлэлцэх асуудалд оруулах эсэхийг ТУЗ шийдвэрлэнэ.
- 7.4. Нэр дэвшигчийг жагсаалтад оруулахаас татгалзсан бол энэ тухай үндэслэл бүхий тайлбарыг холбогдох бичиг баримтад хавсарган шийдвэрийг гаргаснаас хойш ажлын тав (:) өдрийн дотор хувьцаа эзэмшигчид хүргүүлнэ.
- 7.5. ТУЗ-д нэр дэвшигч хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэх асуудлын жагсаалтад оруулахаас өмнө нэрээ татаж авах эрхтэй.
- 7.6. ТУЗ-ийн гишүүн томилогдсоноос хойш ажлын 10 хоногт ТУЗ гишүүний эрх, үүрэг, хариуцлагыг тусгасан “санамж бичиг”-ийг үйлдэн баталгаажуулна.
- 7.7. ТУЗ гишүүдийн цалин урамшууллын хэмжээ, олгох хэлбэр, давтамжийг ХЭХ-аар ил тод хэлэлцэн батлуулна.
- 7.8. ТУЗ-ийн гишүүнийг анх томилогдоход чиглүүлэх сургалтыг зохион байгуулж, ТУЗ болон компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг өгнө.

НАЙМ. ГИШҮҮНЭЭР СОНГОХ БА ЧӨЛӨӨЛӨХ

- 8.1. Гишүүдийг кумулятив (сонгогч хэд хэдэн саналыг нэр дэвшигчийн тоогоор өгч дараа нь хуваах сонгуулийн зарчим) аргаар сонгоно.
- 8.2. Сонгуулийг кумулятив аргаар явуулахад хувьцаа эзэмшигч өөрийн саналаа нэг нэр дэвшигчид өгөх эсвэл өөрийн сонгосон нэр дэвшигчдийн дунд хуваарилж болно.
- 8.3. Хамгийн олон тооны санал авсан нэр дэвшигчдийг ТУЗ-ийн гишүүнээр сонгогдсонд тооцно.
- 8.4. ТУЗ-ийн сонгуультай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийг дараах мэдээллээр хангана. Үүнд:
 - 8.4.1. Нэр дэвшигчийн нэр, нас, боловсрол;
 - 8.4.2. Өнгөрсөн таван (5) жилд эрхэлсэн ажлыг нь оролцуулан мэргэжлийн туршлага;
 - 8.4.3. Нэр дэвших үедээ хашиж буй ажил, албан тушаал;
 - 8.4.4. Нэр дэвшигчийн бусад аж ахуйн нэгжид хашиж буй удирдах болон бусад албан тушаалууд;
- 8.5. ХЭХ-аас ТУЗ-ийн бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгож болно.
- 8.6. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрх дараах тохиолдолд дуусгавар болно. Үүнд:
 - 8.6.1. Чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан /энэ тохиолдолд 2 сарын өмнө хүсэлтээ бичгээр ирүүлнэ/
 - 8.6.2. Удаан хугацаагаар бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болсон,

- 8.6.3. Эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн болох нь тогтоогдсон, санхүү, татвар, үнэт цаасны чиглэлээр хууль тогтоомж зөрчсөн болох нь хууль хяналтын байгууллагаас тогтоогдсон,
- 8.6.4. Нас барсан
- 8.6.5. Хуулиар тодорхойлогдсон бусад тохиолдол
- 8.7. ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийг дуусгавар болгосон тохиолдолд тухайн гишүүнийг орлох этгээдийг дараагийн сонгууль хүртэл ТУЗ-ийн дэргэдэх ЦУНДХ-оос санал болгосны дагуу ТУЗ-өөс түр томилох ба томилогдсон этгээд нь КТХ-ийн 77.6-д зааснаар хараат бус гишүүнд тавигдах шаардлагыг хангасан байна.
- 8.8. Хэрэв ТУЗ-ийн гишүүдийн 50-иас илүү хувь нь ажиллах боломжгүй бол ТУЗ-өөс шинэ ТУЗ байгуулах талаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал зарлах шийдвэр гаргах ба ийнхүү гаргахаас өөр бусад шийдвэр гаргах эрхгүй.

ЕС. ЦАЛИН ХӨЛС, УРАМШУУЛАЛ

- 9.1. ТУЗ-ийн үндсэн гишүүдийн цалин, нэмэгдэл хөлс, үйл ажиллагаанд шаардагдах зардлын төсвийн хэмжээг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрт үндэслэн тогтооно.
- 9.2. ТУЗ-ийн гишүүдийн цалин хөлс дараах хэлбэртэй байж болно. Үүнд:
- 9.2.1. ТУЗ-ийн ээлжит хурлын тогтмол цалин
- 9.2.2. ТУЗ-ийн ээлжит бус хурлын урамшуулал /бүтээгдэхүүнээр/

АРАВ. ТУЗ-ИЙН ХУРАЛ

10.1. ТУЗ-ийн хурлын зохион байгуулалт:

- 10.1.1. ТУЗ-ийн үйл ажиллагаа явуулах хэлбэр нь ТУЗ-ийн хурал байх ба хурлыг цахимаар хийж болно. Хурал нь ээлжит болон ээлжит бус байх ба ээлжит хурлыг улиралд 1 удаа ТУЗ-ийн дарга зарлан хуралдуулна.
- 10.1.2. Ээлжит бус хурлыг ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал, удирдлагын багийн гишүүдийн саналын дагуу хуралдуулж болно.
- 10.1.3. ТУЗ-ийн хурал хуралдуулах саналыг бичгээр үйлдэж компани руу баталгаат шуудангаар илгээх эсвэл компанийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргад хүргүүлнэ.
- 10.1.4. Хүсэлт хүлээн авснаас хойш ажлын арав хоногийн дотор ТУЗ-ийн дарга ТУЗ-ийн хурлыг зарлан хуралдуулна.
- 10.1.5. ТУЗ-ийн ээлжит болон ээлжит бус хурал хуралдахаас 2-оос доошгүй хоногийн өмнө ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хурал болох огноо, газар, эхлэх цаг, хэлэлцэх асуудлын талаарх мэдэгдэл, хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой болон хуралд бэлтгэхэд шаардлагатай мэдээлэл, танилцуулах материал /тайлан, төлөвлөгөө, ажлын төсөл г.м/-ыг эцсийн байдлаар бэлтгэн ТУЗ-ийн гишүүдэд хүргүүлсэн байна.
- 10.1.6. ТУЗ-ийн дарга хурал зарлахаас үндэслэлгүйгээр татгалзсан эсвэл хүндэтгэн үзэх шалтгааны улмаас үүргээ гүйцэтгэх боломжгүй бол, ТУЗ-ийн бусад гишүүн тус хурлыг зарлаж болно.
- 10.1.7. ТУЗ-ийн анхны хурлыг ТУЗ-ийг сонгосноос хойш нэг сарын дотор хуралдуулах бөгөөд энэ хурлаар ТУЗ-ийн даргыг сонгоно.
- 10.1.8. ТУЗ-ийн хуралд ТУЗ-ийн нарийн бичиг болон бусад холбогдох албан тушаалтнуудын бэлтгэн оруулсан мэдээллийг танилцуулна. (ТУЗ-ийн хурлын материал) ТУЗ-ийн хурлаар хэлэлцэхээр товлоогүй боловч тооцоо судалгаа шаардахгүй асуудлыг гишүүдийн дийлэнх олонхын зөвшөөрснөөр хэлэлцэж болно.



НС



- 10.1.9. ТУЗ-ийн хурлын материалд тухайн хурлаар хэлэлцсэн асуудалтай холбоотой тайлан, дүгнэлт, мэдээ баримт болон бусад шаардлагатай баримт бичгийг хавсаргана.
 - 10.1.10. ТУЗ-ийн хурлын ирц гишүүдийн дийлэнх олонх оролцсоноор хүчин төгөлдөр болох бөгөөд хуралд оролцож буй гишүүдийн дийлэнх олонхийн саналын дагуу гаргана.
 - 10.1.11. Хурал дээр санал хураалт явуулах үед гишүүн тус бүр нэг саналын эрхтэй байна.
 - 10.1.12. ТУЗ-ийн нэг гишүүний саналын эрхийг нөгөө гишүүнд шилжүүлэх, саналын эрхийг өөр хүнд итгэмжлэлээр дамжуулах үйл ажиллагааг зөвшөөрөхгүй.
 - 10.1.13. Сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах шийдвэрийг хуульд заасан хоорондоо ашиг сонирхлын зөрчилгүй гишүүдийн олонхийн саналын дагуу гаргана. Нийт гишүүд тухайн хэлцэлд ашиг сонирхлын зөрчилтэй, эсвэл шийдвэр гаргах гишүүд дотор хараат бус гишүүн байхгүй тохиолдолд ХЭХ-аас дээрх хэлцлийг батлах шийдвэр гаргана. Гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдтэй байгуулах гэрээний нөхцөлийг батлах шийдвэрийг санал хураалтад оролцож буй гишүүдийн дийлэнх олонхийн саналын дагуу гаргана. Гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд энэ төрлийн асуудлаарх санал хураалтад оролцохгүй.
 - 10.1.14. Хуралд оролцоогүй ч бичгээр саналаа гаргасан гишүүдийн саналыг хурлыг ирц бүрдэлт болон санал хураалтын дүн гаргахад тооцож үзнэ.
 - 10.1.15. ТУЗ-ийн нарийн бичгийн дарга саналын хуудсаар хуралд оролцсон гишүүдийн санал хураалтын дүнгийн талаар тэмдэглэлийг хөтөлнө.
 - 10.1.16. Гүйцэтгэх захирал нь ТУЗ-өөс өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн явц болон ажлын явцад тулгарч буй асуудлыг ТУЗ-ийн даргад 30 хоног тутам мэдээлж байх үүрэгтэй.
 - 10.1.17. ТУЗ-ийн хурлаас тогтоол гарах ба ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж, компанийн тэмдэг дарж баталгаажуулна.
- 10.2. **ТУЗ хурлын дэг:**
- 10.2.1. ТУЗ хуралдуулах тогтоол гаргах үед хурлын дэг, хуралд оролцох хүмүүсийн нэрсийн жагсаалтыг хамт батлана.
 - 10.2.2. Хэлэлцэх асуудлыг хуралд бэлтгэсэн холбогдох ажилтан танилцуулж, гишүүд нэмэлт асуулт асууж танилцан, хэлэлцүүлгийг явуулна.
 - 10.2.3. Хурлын дарга гишүүдийн саналд үндэслэн хурлаас гаргах тогтоолыг томъёолно.
 - 10.2.4. ТУЗ гишүүдийн саналыг нээлттэйгээр, ил авах, нууцаар хураах гэсэн байдлаар явуулна.
 - 10.2.5. ТУЗ гишүүд гүйцэтгэх удирдлагын багт үүрэг даалгавар, санал зөвлөмж өгнө.
- 10.3. **ТУЗ-ийн хурлын тэмдэглэл:** ТУЗ-ийн нарийн бичгийн дарга хурлын тэмдэглэлийг хөтөлнө. Хурлын явцад аудио бичлэг хийх ба ТУЗ-ийн нарийн бичгийн дарга архивлаж хадгална.
- 10.3.1. ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг хурал дууссанаас хойш ажлын таван (5) өдрийн дотор үйлдэнэ. Хурлын протокол дараах мэдээллээс бүрдэнэ. Үүнд:
 - 10.3.1.1. Компанийн албан ёсны нэр ба хаяг;
 - 10.3.1.2. Хурал болох газар (хаяг), эхлэх цаг;
 - 10.3.1.3. Хурлын хэлэлцэх асуудал;
 - 10.3.1.4. Хуралд оролцож байгаа оролцогчид болон хурлын ирцийн тоо;
 - 10.3.1.5. Хуралд биечлэн оролцоогүй боловч бичгээр саналаа өгсөн гишүүд;
 - 10.3.1.6. тэмдэглэлийн үнэн зөвийг хариуцсан ТУЗ-ийн дарга, Санал хураасан асуудлууд, санал хураалтын дүн;
 - 10.3.2. ТУЗ-ийн хурлын тэмдэглэл дээр хуралд оролцсон нийт гишүүд, ТУЗ-ийн дарга, нарийн бичиг гарын үсэг зурах ба тэмдэглэлийн үнэн зөвийг ТУЗ-ийн дарга хариуцна.
 - 10.3.3. Гишүүдийн бичгээр гаргасан саналуудыг тэмдэглэлд хавсаргана. Гишүүн тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзсан бол эн тухай бичгээр тайлбар бичиж хавсаргана.

- 10.3.4. Саналын хуудсаар хураасан санал, саналын дүнгийн талаар тэмдэглэлийг саналын хуудас хүлээн авах эцсийн өдрөөс хойш ажлын гурван (3) хоногийн дотор үйлдэх ба тэмдэглэлд ТУЗ-ийн дарга, нарийн бичиг гарын үсэг зурна.
- 10.3.5. Тэмдэглэлийг буруу хөтөлсөн нь тухайн хурлаас гарсан шийдвэрийг хүчингүй болгох үндэслэл болохгүй.
- 10.3.6. Эрх бүхий этгээд ТУЗ-ийн хурлын тэмдэглэлтэй ТУЗ-ийн даргын бичгээр өгсөн зөвшөөрлийн дагуу танилцаж болно.
- 10.3.7. Компани ТУЗ-ийн хурлын тэмдэглэлийг компанийн байрандаа хадгална.
- 10.4. ТУЗ-ийн шийдвэр хүчин төгөлдөр болох
 - 10.4.1. ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлж байгаа асуудлыг шийдвэрлэхэд ТУЗ-ийн гишүүн бүр 1 саналын эрхтэй байна.
 - 10.4.2. ТУЗ-ийн хуралд оролцож байгаа гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэр хүчин төгөлдөр болно.
 - 10.4.3. ТУЗ-ийн гишүүн тодорхой шалтгааны улмаас хуралд оролцох боломжгүй тохиолдолд бичгээр урьдчилан санал өгөх боломжтой бөгөөд энэ тохиолдолд хуралд оролцсонд тооцож, ирц болон саналыг бүртгэн авна.
 - 10.4.4. Хэлэлцэж буй асуудалд ТУЗ-ийн гишүүн саналын эрхгүй тохиолдолд санал хураалтанд оролцуулахгүйгээр саналын эрхтэй гишүүдийн дийлэнх олонхын саналаар шийдвэрлэнэ.
 - 10.4.5. ТУЗ-ийн хурлаас тогтоол гарах бөгөөд тогтсон загвар бүхий бланк дээр хэвлэн, ТУЗ-ийн дарга гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно. Шаардлагатай тохиолдолд хурлын тогтоолд уг шийдвэрийг зөвшөөрсөн гишүүд гарын үсэг зурж баталгаажуулна.
- 10.5. Эчнээ санал хураалтаар шийдвэр гаргах
 - 10.5.1. ТУЗ эчнээ санал хураалтаар шийдвэр гаргаж болох бөгөөд ТУЗ-ийн хурлыг эчнээ санал хураалтаар явуулах тохиолдолд хурлын мэдэгдэл, хэлэлцэх асуудал болон холбогдох материалыг саналын хуудсын хамт хурал хуралдахаас ажлын 3-с доошгүй хоногийн өмнө хэвлэмэл байдлаар эсвэл мэйлээр гишүүдэд хүргүүлнэ.
 - 10.5.2. ТУЗ гишүүд саналын хуудсыг хүлээж авснаас хойш ажлын 2 хоногт багтаан саналаа ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар дамжуулан ТУЗ-ийн даргад хүргүүлэх ба энэ хугацаанд саналаа ирүүлээгүй тохиолдолд түүнийг тухайн асуудлаар санал өгөхөөс түдгэлзсэнд тооцно.

АРВАН НЭГ. ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ХОРООД

- 11.1. ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн
 - 11.1.1. ТУЗ урьдчилсан хэлэлцүүлэг хийх, зөвлөлийн бүрэн эрхийн хүрээнд чухал асуудлуудыг хэлэлцэх зорилгоор дэргэдээ Аудитын хороо, Цалин урамшуулал болон нэр дэвшүүлэх хороо, Стратеги, бизнес хөгжлийн хороо гэсэн 3 хороотой байна.
 - 11.1.2. ТУЗ-ийн дэргэдэх хороод тус бүр 3-аас доошгүй гишүүний бүрэлдэхүүнтэй байх ба түүний 2/3-оос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна. Нэг гишүүн хоёр дэд хорооны гишүүн байж болох ба түүнээс дээш хорооны гишүүнээр ажиллахгүй.
 - 11.1.3. Хорооны дарга, гишүүдийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн, гишүүдийн санал хураалтаар нийт гишүүдийн олонхын саналаар томилж, ТУЗ-ийн тогтоолоор баталгаажуулна.
 - 11.1.4. Хорооны гишүүдийн бүрэн эрхийн хугацаа ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаатай ижил байна.
- 11.2. ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа



- 11.2.1. Хороод тодорхой чиг үүрэгтэй байх бөгөөд шаардлагатай тохиолдолд хөндлөнгийн шинжээч, мэргэжилтнүүд авч ажиллуулж болох ба тэдгээрийн ажлын хөлсийг тодорхойлно.
- 11.2.2. Хорооны хурлыг хорооны дарга, хорооны гишүүн, мөн компанийн ТУЗ-ийн шийдвэрийн дагуу хуралдуулна.
- 11.2.3. Хорооноос дүгнэлт, зөвлөмж гаргах ба түүнийг ТУЗ-ийн хуралд танилцуулж, хуралд оролцсон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэн, ТУЗ-ийн тогтоолоор баталгаажуулна. Хороод Компанийн тухай хуульд заасан зарим асуудлаар шийдвэр гаргах бүрэн эрхтэй байна.
- 11.2.4. Хороод тодорхой эрх үүрэг, бүрэн эрх, үйл ажиллагааг тодорхой заасан журам дүрмийг боловсруулан мөрдөх ба жил бүр ТУЗ-ийн хуралд хийсэн ажлын тайланг танилцуулна.

АРВАН ХОЁР. ТУЗ-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ДҮГНЭХ

12.1. ТУЗ-ийн үйл ажиллагааг төлөвлөх

- 12.1.1. ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд үндэслэн ТУЗ-ийн жилийн төлөвлөгөөг боловсруулж, оны эхний ТУЗ-ийн хурал дээр хэлэлцэн батална.
- 12.1.2. Журмын 12.1.1-д заасан ирэх жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөг ТУЗ-ийн дэргэдэх Стратеги, бизнес хөгжлийн хорооноос боловсруулан ТУЗ-ийн хуралд танилцуулна.

12.2. ТУЗ-ийн үйл ажиллагааг үнэлэх

- 12.2.1. ТУЗ-ийн дэргэдэх ЦУНДХ-оос ТУЗ-ийн гишүүний ажлын үнэлгээний асуулгын хүснэгтийг боловсруулан гаргах ба гишүүд жилийн эцэст тухайн жилд хийсэн ажлын тайлангаа бичин, уг асуулгын дагуу өрийн үйл ажиллагааг үнэлж ЦУНДХ-д ирүүлнэ.
- 12.2.2. ТУЗ-ийн хараат бус гишүүд жил бүрийн эцэст компанийн болон ТУЗ-ийн үйл ажиллагаатай холбоотой өөрийн санаачилсан, хийсэн ажлын гүйцэтгэлийн тайланг бэлтгэн ЦУНДХ-д ирүүлнэ.
- 12.2.3. ТУЗ болон түүний дэргэдэх хороод, гишүүдийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг хөндлөнгийн этгээдээр гүйцэтгүүлж болно.

12.3. ТУЗ-ийн үйл ажиллагааг тайлагнах

- 12.3.1. ТУЗ-ийн дэргэдэх ЦУНДХ гишүүдийн болон хороодын ажлын гүйцэтгэлийн тайланг авч хороогоороо хэлэлцээд дүгнэлтийг ТУЗ-ийн хуралд танилцуулна.
- 12.3.2. ТУЗ-ийн дарга, хороодын дарга нар нь жил бүрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үеэр үйл ажиллагааны тайланг тайлагнана.

АРВАН ГУРАВ. ТУЗ-ИЙН ГИШҮҮДИЙН МӨРДӨХ ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга нь ёс зүйн дараах нийтлэг зарчмыг мөрдөнө.

- 13.1. Ажил үүргээ гүйцэтгэхдээ компанийн эрх ашгийг нэн тэргүүнд тавьж, аливаа шударга бус байдлаас ангид байж ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийж ажиллана.
- 13.2. Өөрийн үйл ажиллагаа, зан байдалдаа хяналт тавьж компанийн ажилтнууд болон бизнесийн хамтрагчдын компанид итгэх итгэл, үнэлэх үнэлэмжид эергээр нөлөөлж, үлгэр жишээ болохуйц биеэ авч явах ёстой.
- 13.3. Аливаа гэрээ хэлцэл, гүйлгээ хийхдээ компаниас бизнесийн өндөр ёс зүй, хувь хүний шударга зарчимч байдлыг баримтлан ажиллана.

- 13.4. Хамтрагчид болон хамтран ажиллагсадтайгаа адил тэгш, үнэнч, шударга, ёс зүйтэйгээр харилцана. Бусад хүмүүсийг үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, үүсэл, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор ялгаварлан гадуурхах аливаа үйлдлийг цээрлэнэ.
- 13.5. Өөрийн эрхэлж буй албан тушаалыг ашиглан компанийн мэдээлэл, эд хөрөнгийг өөрийн болон бусдын ашиг хонжооны төлөө зүй бусаар ашиглах ёсгүй ба компанитай шууд болон шууд бусаар өрсөлдөх ёсгүй.
- 13.6. ТУЗ-ийн дарга, гишүүн, нарийн бичгийн дарга нь дараах ашиг, сонирхлын зөрчлийг зохицуулах журмын дагуу ажиллана. Үүнд:
- 13.6.1. Компани, түүний салбар компанид мэргэжлийн хөрөнгө оруулалт оруулах гэх мэт аливаа үйл ажиллагаанд оролцоход ашиг сонирхлын зөрчилтэй (шууд болон шууд бус) байдал байгаа бол энэ талаар компанид нэн даруй бичгээр мэдэгдэх;
- 13.6.2. Албан тушаалын эрх мэдлийнхээ хүрээнд гаргасан шийдвэр, үйл ажиллагааны шагнал эсвэл шагналд тооцогдохоор ямар нэгэн бэлэг, үйлчилгээ, давуу байдлыг бусдаас олж авахгүй байх;
- 13.6.3. Албан үүргээ гүйцэтгэх үедээ олж мэдсэн нууц, дотоод болон бусад албан мэдээллийг ажиллах хугацаандаа болон ажлаас чөлөөгдсөний дараах гурван (3) жилийн турш задруулахгүй, хувийн ашиг сонирхол болон гуравдагч этгээдийн ашиг сонирхлын төлөө ашиглахгүй байх;
- 13.6.4. ТУЗ-ийн хараат бус гишүүд хараат бус байдалд нь нөлөөлөх аливаа үйл ажиллагаанаас татгалзана. Хэрэв нөхцөл байдал байдалд өөрчлөлт орсны улмаас хараат бус гишүүн хараат бус байх боломжгүй болсон бол тухайн гишүүн энэ талаар ТУЗ-д бичгээр нэн даруй мэдэгдэнэ.
- 13.7. Энэхүү журмын 13.6 дахь зүйлд заасан нөхцөлийг зөрчсөн гишүүд өөрсдийн буруутай үйл ажиллагаа, албан үүргээ биелүүлээгүйгээс үүдэн компанид учирсан хохиролд хариуцлага хүлээнэ.
- 13.8. Компанид алдагдал учруулах шийдвэрийн эсрэг санал гаргасан эсвэл санал хураалтад оролцоогүй гишүүд учирсан хохиролд хариуцлага хүлээхгүй.
- 13.9. Гишүүдэд хариуцлага ногдуулахдаа гэм буруугийн хэмжээ, бусад холбогдох нөхцөл байдлыг харгалзан үзнэ.

АРВАН ДӨРӨВ. ХАРИУЦЛАГА

- 14.1. Журамд заасан үүргийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаагүй, зөрчсөн үйл ажиллагаа явуулсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.